

Гадаадын дадлагажигч, оюутан, усан онгоцны ажилчдын анхааралд

Мах, махан бүтээгдэхүүнийг авч оруулахгүй байх

- Ихэнх улс орноос, хяналт шалгалтын бичиг баримтгүйгээр мах, хиам, зайдас, бекон зэрэг мах, махан бүтээгдэхүүнийг Япон улсын хилээр оруулахыг хориглоно.
- Бага оврын шуудангаар мах, махан төрлийн бүтээгдэхүүн зэргийг хийж явуулахгүй байхыг гэрийнхэн болон найз танилдаа дамжуулна уу.
- Бага оврын ачаа, шуудангаар хяналт шалгалтанд ороогүй мах, махан бүтээгдэхүүн хүлээн авсан тохиолдолд ойролцоох Мал эмнэлэг, хорио цээрийн хяналтын улсын албанд нэн даруй мэдэгдэнэ үү.

✳импортын хяналт, шалгалт хийлгэлгүй малын гаралтай бүтээгдэхүүн авч орсон тохиолдолд, 3 хүртэлх жилийн хорих ял эсвэл 3 сая иен хүртэлх мөнгөн торгууль оногдуулна.(Аж ахуйн нэгж бол 50 сая хүртэлх иен)

Ариутгал хийнэ!

- Гадаадад байхдаа хэрэглэж бохирдсон ажлын хувцас, ажлын гутал, түрүүтэй гутал зэргийг битгий авч ирээрэй.
- Гадаадад байхдаа мал сүрэгтэй газар очсон болон японд мал амьтанд хүрэх төлөвлөгөөтэй байгаа хүн, хилээр орох үедээ гар тээшээ авах хэсэгт байгаа "Мал эмнэлэг, хорио цээрийн хяналтын лавлах"-д түр хүрч ирнэ үү.

Гадаадад байхдаа мал, амьтанд хүрэхээс зайлсхийх

- Япон улсад ирэхээс өмнөх 1 долоо хоногийн дотор, мал амьтанд хүрэхээс зайлсхийнэ үү.
- Япоң улсад ирснээс хойшхи 1 долоо хоногт, мал амьтанд хүрэхээс зайлсхийнэ үү.

Animal Quarantine Service Ministry of
Agriculture,
Forestry and Fisheries JAPAN

<http://www.maff.go.jp/aqs/languages/info.html>